



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 31 болон 32 дахь долоо

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 7-р сарын 24-өөс 8-р сарын 05-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 20 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Евростатын урьдчилсан тооцоогоор **Евро бүсийн эдийн засаг 2020 оны 2-р улиралд өмнөх улирлаас 12.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 15 хувиар агшлаа.** Голлох эдийн засгуудыг дурдвал Испанийн эдийн засаг өмнөх улирлаас 18.5 хувиар, Францын эдийн засаг 13.8 хувиар, Италийн эдийн засаг 12.4 хувиар, Германы эдийн засаг 10.1 хувиар тус тус буураад байна.
- **Европын Холбоо** 7-р сарын 20-нд хуралдаж, цар тахалтай тэмцэх, эдийн засгийг сэргээх төсвийн багц арга хэмжээний хүрээнд **750 тэрбум евро** (860 тэрбум ам.доллар)-ийн **бонд** худалдах зөвшилцөлд хүрлээ. Босгосон санхүүжилтийг Европын холбооны 27 орноос санхүүжилтийн хэрэгцээ шаардлага өндөртэй улсуудад цар тахлын тархалт, эдийн засгийн хүндрэлийг шалгуур болгон олгох юм. Үүнээс 390 тэрбум еврог буцалтгүй тусламж хэлбэрээр, 360 тэрбум еврог зээл хэлбэрээр олгохоор байна.
- **АНУ-ын эдийн засаг** урьдчилсан гүйцэтгэлээр энэ оны **2-р улиралд өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар, өмнөх улирлаас жилийн 32.9 хувиар агшжээ.** Эдийн засаг ийнхүү огцом агшихад цар тахлын улмаас дийлэнх мужуудад хөл хорио үргэлжилж, хэрэглээ, хөрөнгө оруулалт огцом хумигдсан нь нөлөөлсөн байна. Тухайлбал, хэрэглээ -25 нэгж хувь, хөрөнгө оруулалт -9.4 нэгж хувь, цэвэр экспорт 0.7 нэгж хувь (экспорт -9.4 нэгж хувь, импорт 10.1 нэгж хувь), Засгийн газрын хэрэглээ 0.8 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Хувийн хэрэглээний бууралтын дийлэнх хувийг үйлчилгээ, үүн дотроо эрүүл мэндийн үйлчилгээний бууралт голчлон тайлбарлаж байна.
- **АНУ-ын Холбооны нөөцийн банк** 7-р сарын 28-29-ны өдөр хуралдаж **ХНБ-ны хүүг 0-0.25 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргав.** КОВИД-19-ийн улмаас эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлт огцом унасны дараа сүүлийн саруудад тодорхой хэмжээнд эргэж сэргэсэн ч хямралын өмнөх түвшинд хүрэх болоогүй байна. Нийт ажиллах хүчний 15-аас илүү хувь нь ажилгүйдлийн тэтгэмж авч байна. ХНБ-наас АНУ-ын эдийн засаг энэ онд 6.5 хувиар агших төсөөлөлтэй байна. Эдийн засгийн сэргэлт цар тахлын тархалт, түүнийг хэр хурдан хяналтанд оруулахаас шалтгаална гэдгийг ХНБ-ийн тэргүүн Ж.Повел мэдэгдэв. Цаашид Төв банк эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжиж, үнийн тогтвортой байдлыг хангахын тулд бодлогын бүх арга хэрэгслийг ашиглан шаардлагатай

арга хэмжээнүүдийг авахад бэлэн байгаагаа мэдэгдлээ.

- Энэ оны 7-р сарын эцсээс АНУ-ын ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацаа дуусч байгаатай зэрэгцэн **АНУ-ын сенатаас 1 их наяд ам.долларын КОВИД-19-ийн үеийн эдийн засгийг дэмжих нэмэлт багц хөтөлбөр хэрэгжүүлэхээр хэлэлцэж байгааг** мэдээллээ. Уг нэмэлт санхүүжилтэд улсаас олгож буй 7 хоногийн ажилгүйдлийн тэтгэмж 600 ам.доллар байсныг 400 ам.доллар болгох, өрхүүдэд 1 удаагийн 1200 ам.долларын буцалтгүй тусламж олгох зэрэг багтжээ.
- **Фитч агентлаг 7-р сарын 27-ны тусгай тайландаа Коронавирусийн хөгжингүй орнуудын дунд хугацааны эдийн засагт үзүүлэх нөлөөллийг танилцуулжээ.** Уг тайланд сөрөг байгаа үйлдвэрлэлийн зөрүү 2025 онд хаагдах, ДНБ-ий түвшин дунд хугацаанд нэмэгдэх боловч 2025 он гэхэд цар тахлын өмнөх үеэс 3-4 нэгж хувиар бага түвшинд байх, нийлүүлэлтийн сүлжээнд бий болсон доголдлын улмаас урт хугацаанд ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, хөрөнгө оруулалт буурахыг онцолжээ.
- **НҮБ-ийн 8-р сарын 3-ны өдөр нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, хандлага” тайланд цар тахлын хөгжингүй орнуудын хөдөлмөрийн зах зээлд үзүүлж буй нөлөөг** онцолжээ. Ажилгүйдлийн түвшин дийлэнх орнуудад нэмэгдсэн ч цар тахлыг хязгаарлах дотоодын хөл хорио тогтоох арга хэмжээ, хөл хорионы үргэлжлэх хугацаа, нийлүүлэлтийн сүлжээний доголдол зэргээс хамааран улс бүрийн хувьд ажил эрхлэлтэд гарсан өөрчлөлт харилцан адилгүй, мөн залуус, эмэгтэйчүүд, шилжин ажиллагсад зэрэг нийгмийн хамгаалалд бага хамрагдсан нийгмийн бүлгүүдэд цар тахал илүү хүчтэй сөргөөр нөлөөлж буйг онцлов.

- **Азийн аж үйлдвэрийн нэгдсэн PMI индекс 7-р сард өмнөх сараас нэмэгдэв.** Үүнд БНХАУ, Австрали, Тайванийн аж үйлдвэрийн PMI индекс 50-аас дээгүүр түвшинд хадгалагдсан бол Япон, Өмнөд Солонгос, Индонезийн PMI индекс хүлээлтээс ихээр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Хэдийгээр Япон, Өмнөд Солонгос, Индонезийн PMI индексүүд хүлээлтээс давж сайжирсан ч 50-аас доогуур түвшинд хэвээр буюу аж үйлдвэрийн салбарууд нь агшилттай байв. Харин PMI индекс өмнөх сараас буурсан эдийн засгууд нь Вьетнам, Энэтхэг, Филиппин байсан бол Малайзын PMI индекс 50 хүрч агшилт, тэлэлтийн завсарт хадгалагдав. Азийн аж үйлдвэрлэлийн цаашдын төлөв цар тахлын өрнөлөөс голлон хамаарах хэвээр байгаа бөгөөд 7-р сарын сүүлээс эхлэн Азид өдрийн 50,000-аас их КОВИД-19-ийн шинэ тохиолдол бүртгэгдээд байна. Иймд Австрали зэрэг улс орнуудад хориг арга хэмжээг сулруулж эхлээд байсан ч эргэн чангаруулахад хүрээд байна.
- Энэ оны эхний хагаст мөнгөний эрчимтэй тэлэх бодлого хэрэгжүүлсэн **Азийн Төв банкуудын дийлэнх нь 7-р сард бодлогын хүүгээ хэвээр үлдээсэн** бол Малайз, Индонезийн Төв банкууд хүүгээ 25 нэгж хувиар буурууллаа.
- Цар тахлын улмаас эдийн засгийн үйл ажиллагаа хумигдаж, инфляцын эрсдэл багассан тул **ОХУ-ын Төв банк 7-р сарын 24-нд хуралдаж, бодлогын хүүгээ 25 нэгж хувиар бууруулан түүхэн доод 4.25 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.** Төв банкнаас эдийн засаг энэ онд 4.5-5.5 хувиар агших, хямралын өмнөх түвшиндээ эргэн очиход 1.5 жил шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд инфляц 2021 оноос алгуур нэмэгдэж, 2022 онд зорилтот 4 хувьд хүрэхээр төсөөлж байна.

**Эх сурвалж:**

1. Eurostat, [GDP down by 12.1% in the euro area and by 11.9% in the EU](#)
2. Bloomberg, [EU Clinches Massive Stimulus Deal to Bind Continent Together](#)
3. Federeal Reserve, [Monetary policy decision press release](#)
4. Fitch ratings, [Coronavirus GDP Impact to Persist in Medium Term](#)
5. Focus Economics, [U.S. Economic Outlook \(June, 2020\)](#)
6. Moody's analytics, [Unprecedented Stimulus Lessens the Blow from Real GDP's Record Dive](#)
7. PricewaterhouseCoopers, [Global Economy Watch - Projections](#)
8. The New Zealand Treasury, [Weekly Economic Update - 31 July 2020](#)
9. United Nations, [World Economic Situation And Prospects: August 2020 Briefing, No. 140](#)
10. Nikkei, [Japan reveals 87 projects eligible for 'China exit' subsidies](#)
11. Deloitte, [Weekly global economic update August 2020](#)
12. Bloomberg, [Asia Insight: PMIs show improvement, virus resurgence a new blow](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Дэлхийн банк 2020 оны 7-р сарын төсөөллөөр **БНХАУ-ын эдийн засаг энэ онд 1.6 хувиар өсөх** төсөөлөл гаргажээ. Энэ нь өмнөх улирлын төсөөллөөс 0.7 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Хэдийгээр нийлүүлэлтийн хязгаарлалтуудыг зөөлрүүлсэн ч цар тахлын улмаас дотоод болон гадаад эрэлт сул байгаа нь эдийн засгийн сэргэлтийг хязгаарлана гэж үзэж байна.
- **БНХАУ-ын аж үйлдвэрийн Caixin PMI индекс** 6-р сард 51.2 хүрсэн бол **7-р сард 52.8 буюу 2011 оны эхний үеэс өндөр түвшинд хүрч нэмэгдэв**. Үүнд гадаад эрэлт нэмэгдэн, шинэ захиалгын тооны өсөлт хадгалагдсан нь нөлөөлөв. “Дотоодын эдийн засгийн идэвхжил сайжирч байгаа хэдий ч гадаад эрэлт болон ажил эрхлэлт сул байгааг онцгойлон анхаарах хэрэгтэй” гэж “The Caixin Global”-аас анхаарууллаа. Түүнчлэн “The Caixin Global” -ийн судалгаагаар экспортын эрэлт 7 дахь сардаа дараалан буурсан дүнтэй байна.
- **БНХАУ-ын аж үйлдвэрийн албан ёсны PMI индекс** 6-р сард 50.9 хүрсэн бол **7-р сард хүлээлтийг давж, 51.1-т хүрч нэмэгдэв**. Эрэлт нэмэгдсэн нь үүнд голлон нөлөөлсөн ба ажил эрхлэлтийн бүрэлдэхүүн индекс 50-аас доогуур түвшинд хадгалагдсан нь компаниуд ажилчдын төвлөрлийг бууруулсан хэвээр байгааг илэрхийлж байна.
- **БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн PMI** 5-р сард 50.9, 6-р сард 49.3 байсан бол 7-р сард 49.2 болж, тус салбарын үйлдвэрлэл агшлаа. Гангийн эрэлт саарч, үерийн улмаас тээвэрлэлтэд саатал гарсан тул үйлдвэрлэл ийнхүү удааширчээ. БНХАУ-ын ган, төмрийн ассиоцацийн мэдээлснээр гангийн өдрийн дундаж үйлдвэрлэл 7-р сард өмнөх сараас 1.09 хувиар буурсан байна. Харин **БНХАУ 7-р сард экспортоос давсан хэмжээгээр ган импортлосон нь 2009 оноос хойших хамгийн өндөр дүн байв**. Өнгөрсөн сард ажиглагдсан энэхүү шилжилт нь дотоодын үйлдвэрлэл бага байгаагийн зэрэгцээ БНХАУ-ын эдийн засагт түүхий эдийн эрэлт өндөр байгааг илэрхийлж байна гэж Рио Тинто Групп онцлов.
- **БНХАУ-ын Ардын Банкны мэдээлснээр үл хөдлөх хөрөнгийн зээл 6 дугаар сарын сүүлээр өмнөх оны мөн үеэс 13.3 хувиар өсч 47.40 их наяд юаньд (6.8 их наяд ам.доллар) хүрсэн байна**. ХАБ-аас мэдэгдсэнээр ипотекийн зээл мөн хугацаанд 15.7 хувиар өсч 32.36 их наяд юаньд хүрсэн дүнтэй байна.

- **2020 оны эхний 6 сарын байдлаар Зүүн-Өмнөд Ази БНХАУ-ын худалдааны гол түнш болоод байна.** Тодруулбал, 2020 оны эхний хагас жилд БНХАУ-ын Евро бүстэй хийх худалдаа 5 хувиар, АНУ-тай хийх худалдаа 10 хувиар тус тус буурсан бол Зүүн-Өмнөд Азитай хийх худалдаа нэмэгджээ. Мөн БНХАУ-ын үйлдвэрлэгчид зардлаа танах, АНУ-ын татвараас зайлсхийхийн тулд Зүүн-Өмнөд Ази руу зарим бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ шилжүүлсэн байна. Сингапур улс өндөр өртөгтэй бүтээгдэхүүний үндсэн нийлүүлэгч болоод байгаа бол Вьетнам улс бага цалингаар үйлдвэрлэл хийхэд тустай байгаа аж. Ингэснээр БНХАУ компаниудаас Зүүн-Өмнөд Азид оруулах ГШХО ч нэмэгдээд байна.
- АНУ болон БНХАУ-ын хоорондын улс төрийн харьцаа хурцадмал байгаа хэдий ч **АНУ-ын компаниудын БНХАУ руу оруулсан гадаад шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2020 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 6 хувиар өссөн дүнтэй байна.** Харин БНХАУ-ын нийт ГШХО мөн хугацаанд 1.3 хувиар буурчээ. АНУ-ын ЗГ-аас БНХАУ улсад Хонг Конгийн үйл ажиллагаатай холбоотойгоор хориг тавиад байгаа нь цаашид АНУ-ын компаниудын хөрөнгө оруулалт буурах эрсдэлийг үүсгэж

байна. Үүний эсрэг БНХАУ-ын ЗГ-аас хөрөнгө оруулагчдыг дэмжиж, таатай нөхцөлийг бүрдүүлж зарим хязгаарлалтуудыг зөөллөх арга хэмжээг авч эхэлжээ. Мөн Японы компаниуд БНХАУ-аас хөрөнгөө татах магадлал өндөр болоод байгааг БНХАУ-ын ЗГ онцгойлон анхаарч байна. Учир нь КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр БНХАУ-аас ирэх бараа ихээр багассан тул, Японы компаниуд өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээг илүү тогтвортой болгохын тулд үйлдвэрлэлээ Япон эсвэл өөр улсууд руу (ихэвчлэн Зүүн-Өмнөд Азийн орнууд) шилжүүлж, компаниа нүүлгэн шилжүүлэх алхмыг хийж эхэлсэн байна.

#### *Эх сурвалж:*

1. World Bank, [China Economic Update - July 2020](#)
2. Caixin Global, [Caixin China Manufacturing PMI Hits Over Nine-Year High](#)
3. Reuters, [China factory activity expands at fastest pace in nearly a decade: Caixin PMI](#)
4. Reuters, [China's outstanding property loans by end-June up 13.1% year-on-year](#)
5. SCMP, [US investors still piling FDI money into China despite rising political tensions](#)
6. SXCoal, [China's Jul steel PMI slides to 49.2](#)
7. Bloomberg, [China commodities today: factory boost spotlights global split](#)
8. Bloomberg, [China Commodities today: steel extends rally as copper retreats](#)
9. Bloomberg, [China React: Caixin PMI shows exports breathe wind into recovery](#)

### 3 МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ 2020/07/31	Өөрчлөлт					
		daily	weekly	monthly	year to date	YoY	
<b>Зэс</b>	6422	0.0%	-0.1%	7.0%	4.2%	12.6%	БНХАУ-ын үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хадгалагдаж, улс орнуудын хөл хорио суларч, эрэлт нэмэгдсэн хэдий ч Азид шинэ тохиолдлууд дахин эрчимтэйгээр бүртгэгдэж эхэлснээр зэсийн үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс бага зэрэг буурахад нөлөөллөө.
<b>Коксжих нүүрс</b>	111.8	-	-	-	-	-39.5%	Худалдааны маргаан, КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт үргэлжлэн буурах төлөв болон БНХАУ-ын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх нөлөөгөөр коксжих нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдаж байна.
<b>Төмрийн хүдэр</b>	108.3	0.0%	1.3%	10.5%	16.9%	3.4%	БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн сэргэлт үргэлжилж, боомтууд дээрх нөөц нэмэгдэж байгаа ба хөл хорионы улмаас Бразил Улсын нийлүүлэлт буурахаар байгаа хэдий ч богино хугацаанд энэ нь шийдвэрлэгдэнэ гэсэн хүлээлтийн нөлөөгөөр төмрийн үнэ өмнөх долоо хоногоос нэмэгдэв.
<b>Алт</b>	1976	-0.1%	1.6%	11.1%	29.2%	34.9%	Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал давамгайлж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлтээс үүдэлтэйгээр үнэ өндөр хэвээр байна.
<b>Газрын тос (Брент)</b>	43.3	-0.8%	-1.1%	0.4%	-35%	-30.6%	АНУ-ын нөөцөд өөрчлөлт ороогүй, олон улсын эрчим хүчний агентлаг газрын тосны эрэлтийг 5-р сарын төсөөллөөс нэмэгдүүлсэн ч КОВИД-19-ийн тархалт, ОПЕК+ нэгдэл нийлүүлэлтээ 8-р сараас танаж эхлэх нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс бага зэрэг буурав.